



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2022 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 02

Номгон

Г Татвар хураалтыг эрчимжүүлэх, төсвийн
орлого нэмэгдүүлэх тухай

Орон нутгийн татварын орлогын гүйцэтгэл 2022 оны 2 дугаар сарын байдлаар 77 хувьтай ихэнх орлогын төлөвлөгөө нэр төрлөөр тасарч орон нутгийн зарлагын эх үүсвэр дутагдаж улс, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг татварын нэр төрөл тус бүрээр жигд ханган биелүүлэх зорилгоор Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5 дахь заалт аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ДААЛГАХ** нь:

Нэг. Сумдын Засаг дарга нарт:

Төсвийн орлогын бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр

1.1. Татварын ерөнхий хууль болон бусад холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах замаар Улс, орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг татварын нэр төрөл бүрээр шат шатанд нь жигд ханган биелүүлэх.

1.2. Татварын урьд онуудын өрийг барагдуулах шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх.

1.3. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 5/17 дугаар Үл хөдлөх эд хөрөнгийн татварын хувь хэмжээг тогтоох тухай, 5/18 дугаар Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг тогтоох тухай, 5/19 дугаар Авто тээврийн болон өөрөө явагч тээврийн хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг шинэчлэн тогтоох тухай тогтоол, 2021 оны 12 дугаар сарын 1-ны өдрийн газрын төлбөрийн хувь хэмжээ тогтоох тухай тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ногдуулалтыг хийх.

1.4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 18/14 дүгээр “Бичил худалдаа, ажил үйлчилгээний албан татварын хэмжээ” тогтоолын хэрэгжилтийг хангаж хувиараа хүн тээвэр, ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэгч лангуу болон ил задгай худалдаа үйлчилгээ эрхлэгчдээс албан татварыг тесөвт төвлөрүүлэх.

1.5.Үл хөдлөх эд хөрөнгийн одоогийн үнэлгээг зах зээлийн бодит үнэлгээгээр шинэчлэн тогтоолгох.

1.6.Төсвийн орлого бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх, иргэдэд цаг заваа хэмнэх боломжийг бүрдүүлэх зорилгоор татвар, төлбөр, хураамжийн хураалтад Пос машин ашиглах, үйлчилгээнд нэвтрүүлэх, Пос машин худалдан авах зардлыг 2022 төсөвт тусган худалдан авах.

1.7.Аливаа бүртгэлгүй болон татвараас зайлсхийсэн татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийг илрүүлэн, далд эдийн засагт байх сонирхол, хандлагыг бууруулж, татварын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх зөвлөгөө, зөвлөмж өгч бүртгэлжүүлэх, татвар ногдуулах.

1.8.Нийгмийн даатгал болон татварын албаны цалингийн сангийн мэдээллийг нэгтгэн уялдуулж бүртгэлийн давхардлыг арилгаж, цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогод ногдуулах албан татварын ногдуулалт, төлөлтийг хянах.

1.9.Засаг дарга, газрын албанаас олгосон газар эзэмших, ашиглах эрх, тэдгээрийн нэгж, талбаруудын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүрэн бүртгэж, цахимжуулахад онцгой анхаарч, газрын төлбөрийн ногдуулалтыг бүрэн хийж дуусгах.

1.10.Газрын төлбөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д заасны дагуу газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй, тухайн газраа зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох.

1.11.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, суманд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийг цахим төлбөрийн баримтын системд бүрэн холбуулж, төлбөрийн баримтын тухай бүр олгуулж хэвших.

1.12.Сумдад үйл ажиллагаа явуулж байгаа ус, рашааны нөөцийг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашиглагч иргэн хуулийн этгээд /Уурын зуух, халуун усны газар, рашаан сувиллын газар, эсгийн, тоосго, блокны үйлдвэр, үдийн цай хөтөлбөрт хүнс нийлүүлэгч аж ахуй нэгж гэх мэт/-ийг бүртгэлжүүлж ус ашиглуулах дүгнэлт гаргуулан, усны нөөц ашигласны төлбөр ногдуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр сумын Засаг дарга, Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа, Байгаль орчин аялал жуулчлалын газар, татварын алба ус ашиглагчийн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан усны

хэмжээг бодитоор тодорхойлон, төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэхэд хамтран ажиллах.

1.13.Түүхэн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудыг хамгаалалтад авч, хуулийн хүрээнд төлбөр хураамжтай болгох.

1.14.Сум орон нутагт үйл ажиллагаа явуулж буй гадны татвар төлөгчдийг тус аймагт үндсэн болон салбараар бүртгүүлэх замаар орон нутгийн төсөвт төвлөрөх татвар, төлбөр, хураамжийг нэмэгдүүлэх, тухайн орон нутагт орлого олж буй иргэд, аж ахуй нэгжүүдийн цалин хөдөлмөрийн хэлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг орон нутагтаа төвлөрүүлдэг болгох,

1.15.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөцөө мэргэжлийн байгууллагаар тогтоолгох, үнэ тогтоож, төлбөртэй ашиглуулах, тухайн сумд 2022 онд хийгдэх бүтээн байгуулалтын ажлуудын зураг төсөвт үндэслэн төсөвт тусгах.

1.16.Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдтэй ажил эхлэх гэрээ байгуулахтай холбогдох байгууллагуудын саналыг тусган, хуульд заасан татвар, төлбөр, хураамжийг аймаг сумын төсөвт төвлөрүүлэх чиглэлийг тодорхой зааж өгөх.

1.17.Татварын улсын байцаагч болон татвар, төлбөр, хураамжийг хураахад хамтран ажилладаг /Санхүү албаны дарга мэргэжилтэн, Байгаль орчны улсын байцаагч, газрын даамал, цагдаагийн хэсгийн төлөөлөгч болон бусад/ албан хаагчдын ажлын уялдааг сайжруулан сум орон нутгийн хэмжээнд нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж тасраад буй орлогууд дээрээ анхаарч ажиллах.

1.18.Дээрх татвар хураалтын үйл ажиллагаанд шаардагдах төсөв санхүү, унаа, шатахууны дэмжлэг үзүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

1.19.Малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг ИТХ-аараа хэлэлцүүлэн батлуулж, уг татварын ач холбогдлыг малчдад сурталчлан таниулж, орлогыг бүрэн төвлөрүүлэх

Татвар төлөгчийн бүртгэл мэдээллийг сайжруулах талаар:

1.20.Татвар төлөгчдийн нарийвчилсан бүртгэл судалгаа мэдээллийн сантай болох, Татварын хэлтэс болон холбогдох байгууллагуудын программ дахь бүртгэлтэй тулгалт хийн зөрүүг арилгах.

1.21.Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг шинэчлэн зохион байгуулах ажлын хүрээнд сүүлийн 4-5 жилийн хугацаанд техник хяналтын үзлэгт

хамрагдаагүй, татвар хураамж төлөөгүй, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, авто тээврийн хэрэгслийг бүртгэлийн сангаас хасах.

1.22. Татвар төлөгчөөр бүртгэлтэй иргэн хуулийн этгээдүүдтэй нэг бүрчлэн холбогдож шинэчилсэн утас, хаягийг сэргээн гаргаж үнэ зөв мэдээллийг татварын баазад оруулах.

Хоёр. Аймгийн татварын хэлтэст:

2.1. Аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг албан татвар төлөгчийн бүртгэлд бүрэн хамруулж, тэдгээрийн борлуулалтын орлогыг цахим баримтын систем /И-баримт/-д бүртгэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах.

2.2. Төрийн бусад байгууллагуудтай хамтран хөрөнгийн татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийг зөрүүг арилган бүртгэлд хамрагдаагүй татвар төлөгчдийг хамруулах.

2.3. НӨАТ-ын буцаан олголтын урамшууллаас хөрөнгийн албан татвар малын тоо толгойн албан татварын өртэй татвар төлөгчдийг өрөө суутган тооцуулах хүсэлт гаргах ажиллагааг орон нутагт идэвхжүүлэх, сургалт сурталчилгаа хийх.

2.4. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг ханггуулж, худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд “e-barimt” системийг нэвтрүүлэхэд анхаарч, тухай бүр баримт олгож байх шаардлагыг хүргүүлж, олгоогүй тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж арга хэмжээ авч ажиллах.

2.5. Үйл ажиллагааны орлого бүхий хувь хүнийг татвар төлөгчийн бүртгэлд бүрэн хамруулах Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 18/14 дүгээр “Бичил худалдаа, ажил үйлчилгээний албан татварын хэмжээ” тогтоолын хэрэгжилтийг хангах.


2.6. Аймаг сумдын төсвийн орлогын гүйцэтгэлийг сар, улирлаар Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумдын Санхүүгийн албатай хамтран хянаж, Сангийн яамны /И-хуулга/-тай тулган баталгаажуулж мэдээний үнэн зөв байдлыг ханган ажиллана.

Гурав. Хяналт, мэдээллийн талаар

3.1. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2022 оны 4 дүгээр сарын 10-ны дотор, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг 2022 оны 11 дүгээр сарын 15-ны дотор тус тус аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст албан бичгээр ирүүлэх.

3.2.Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулах загвар маягтыг хавсралтаар баталсугай.

3.3.Албан даалгаврыг хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын арга хэмжээ авч идэвхийлэн ажиллахыг сумдын Засаг дарга нар, аймгийн Татварын хэлтэс (С.Рэнцэндагва)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс (Байгалмаа)-т үүрэг болгосугай.





Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 28-ны
өдрийн 1/02 дугаар албан даалгаврын хавсралт

АЛБАН ДААЛГАВРЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь тувшин	Хүрэх тувшин
1	2	3	4	5	6
Нэг. Төсвийн орлогын бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр:					
1.1					
1.2					
1.3					
Хоёр. Татвар төлөгчийн бүртгэл мэдээллийг сайжруулах талаар:					
2.1					
2.2					
2.3					

_____оо_____